



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын
төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Аудитын код: УВА-2022/20-14-НА-СТА

Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2022 он	Увс аймаг дахь Төрийн аудитын газар; Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батсайхан Утас: 70453799, Цахим хаяг: batsaikhanS@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2022 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/28

Улаангом

Аудитын тайлан батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар 6.3.1, 6.3.3 дахь заалт, 8 дугаар зүйл, 10 дугаар зүйл, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/207 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд хийсэн УВА-2022/20-14-НА-СТА дугаартай нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталсугай.
2. Аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Сонгуулийн хороонд тус тус хүргүүлсүгэй.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЬ

0200100126

Агуулга:

Хүснэгтийн жагсаалт.....	2
Аудит хийх үндэслэл:	4
Аудитын зорилт:.....	4
Аудитын хамрах хүрээ:	4
Аудитын арга зүй:	4
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:.....	5
Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа:.....	5
Ерөнхий мэдээлэл:.....	5
БҮЛЭГ 1. Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулахад улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Сонгуулийн Ерөнхий хорооноос ирүүлсэн зааврын дагуу хуваарилсан байна	6
○ Аймгийн Сонгуулийн хороо нь Сонгуулийн Ерөнхий хорооноос ирүүлсэн зааврын дагуу төсвийг хуваарилсан байна.....	6-7
БҮЛЭГ 2. Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулахад улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалтын талаар Сонгуулийн Ерөнхий хорооноос зөвлөмж чиглэл өгч ажилласан байна	8
○ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.	8-9
○ Зардлын гүйцэтгэлийг журамд заасны дагуу тайлагнасан байна.....	9-10
○ Хөрөнгийн зарцуулалтын талаар Сонгуулийн Ерөнхий хорооноос зөвлөмж чиглэл өгч ажилласан байна.	10-11
ДҮГНЭЛТ.....	11

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар

Хүснэгтийн жагсаалт:

№	Тайлбар
Хүснэгт № 1	Зардлын төсөв
Хүснэгт № 2	Сумдад хуваарилсан төсөв
Хүснэгт № 3	Батлагдсан төсөв, зарцуулалт
Хүснэгт № 4	Зардлын гүйцэтгэл

Аудит хийх үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Төрийн аудитын байгууллага шалгадагч этгээд үйл ажиллагаандаа төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актыг хэрэгжүүлж байгаа эсэхэд аудит хийнэ”, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8-д “Энэ хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4, 10.5, 10.6, 10.7-д заасан зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд төрийн аудитын байгууллага хяналт тавин, аудит хийж, дүгнэлт гаргана” гэж тус тус заасныг үндэслэн Орон нутгийн нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын зорилт:

Орон нутгийн нөхөн болон дахин сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гарган, тайланг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэлээ.

Энэ зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг хийлээ.

- Орон нутгийн нөхөн болон дахин сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс олгох санхүүжилтийг зөв төлөвлөж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн нөхөн болон дахин сонгууль зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалт, гүйцэтгэлийг зөв тайлагнасан эсэх.

Аудитын хамрах хүрээ:

Аудитад аймгийн Сонгуулийн хороо, Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газар, Баруунтуруун, Давст, Түргэн, Өндөрхангай сумдын сонгуулийн хороодод хуваарилан зарцуулсан төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын баримт материалуудыг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 3000, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817:2020, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Аудит хийх журам”, 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг баримтлан шалгадагч болон хамрагдагч байгууллагын сонгуулийн зардлын тайлан, анхан шатны баримт материалыг шалгах, асуулга лавлагаа авах, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимыг хэрэгжүүлж, төлөвлөсөн арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам";
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн акт;

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, аудитын менежер М.Бат-Амгалан үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор С.Батсайхан, аудитор Ч.Мөнхтогтох, Б.Энхмандал нар хариуцан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрөөс 07 дугаар сарын 08-ны өдрийн хооронд гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл:

Орон нутгийн нөхөн болон дахин сонгуулийг 4 сумын 4 тойрог, 4 хэсгийн хороотойгоор зохион байгуулсан байна.

Орон нутгийн нөхөн болон дахин сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс аймгийн Сонгуулийн хороонд 48.1 сая төгрөг, Улсын бүртгэлийн хэлтэст 6.7 сая, Цагдаагийн газарт 0.8 сая төгрөгийг санхүүжилтийг тус тус олгосон байна.

БҮЛЭГ 1. Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулахад улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Сонгуулийн Ерөнхий хорооноос ирүүлсэн зааврын дагуу хуваарилсан байна.

1.1. Аймгийн Сонгуулийн хороо нь Сонгуулийн Ерөнхий хорооноос ирүүлсэн зааврын дагуу төсвийг хуваарилсан байна.

Сонгуулийн Ерөнхий хорооны 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах журам”-ын 2.1 дэх хэсэгт “Сонгуулийн Ерөнхий Хороо нь сонгуулийн батлагдсан төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу нутаг дэвсгэрийн хэмжээ, сонгогчийн тоо болон сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байр, тэдгээрт ажиллах гишүүдийн тоог харгалзан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо бүрээр хуваарилна” гэж заасны дагуу Увс аймгийн Сонгуулийн хороонд 48.1 сая төгрөгийг хуваарилсан байна.

Дээрх журмын 2.2¹ дахь хэсэгт заасны дагуу зардлын эдийн засгийн ангиллаар дараах байдлаар ангилж ирүүлсэн байна. Үүнд:

		Хүснэгт № 1
д/д	Хуваарилагдсан зардлын нэр	Хуваарилагдсан төсөв /мян.төг/
1	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	150.0
2	Үнэмлэх хэвлэх зардал	200.0
3	Сургалтын зардал	660.0
4	МТБ, даамлын сургалтын зардал	80.0
5	Бичиг хэргийн зардал	1300.0
6	Шуудан холбооны зардал	1600.0
7	Унааны зардал	5040.0
8	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	1200.0
9	Саналын хуудас, ИСР төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх унаа, томилолтын зардал	6890.0
10	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо унааны зардал	260.0
11	Сонгуулийн автоматжуулсан системийн зардал /Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх/	240.0
12	Мэдээ дамжуулах унааны зардал	210.0
13	Сурталчилгааны зардал	2000.0
14	Томилолтын зардал	4178.0
15	Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	20210.0
16	Мэдээлэл технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	2350.0
17	Болзошгүй зардал	1500.0
НИЙТ ДҮН		48068.0

/Эх сурвалж: Увс аймгийн Сонгуулийн хорооны төсвийн тайлан/

¹ Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах журмын 2.2 дахь хэсэгт “Сонгуулийн Ерөнхий Хороо нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комисст дараах зардлыг хуваарилна”, 2.2.1 дэх хэсэгт “Сонгуулийн бичиг баримт болон техник хэрэгслийг сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах, тээвэрлэх зардал”, 2.2.2 дахь хэсэгт “Тогтоол, протокол, албан бичгийн хэвлэмэл хуудас, маягт хэвлүүлэх зардал”, 2.2.3 дахь хэсэгт “Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал” 2.2.4 дахь хэсэгт “Дүн мэдээ дамжуулах зардал”, 2.2.5 дахь хэсэгт “Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал”, 2.2.6 дахь хэсэгт “Сонгуулийн байгууллагын ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон сургалтын зардал”, 2.2.7 дахь хэсэгт “Сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал”, 2.2.8 дахь хэсэгт “Бичиг хэргийн зардал” 2.2.9 дахь хэсэгт “Шуудан холбооны зардал”, 2.2.10 дахь хэсэгт “Унааны зардал”, 2.2.11 дэх заалтад “Албан томилолтын зардал”, 2.2.12 дахь заалтад “Үнэмлэх хэвлэх зардал”, 2.2.13 дахь заалтад “Сурталчилгааны зардал”, 2.2.14 дахь заалтад “Болзошгүй зардал”, 2.2.15 дахь заалтад “Бусад зардал”

Дээрх хуваарилагдсан төсвөөс журмын 2.3² дахь хэсэг, Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 3/51, 2022 оны 06 дугаар сарын 07-ний өдрийн 3/82 дугаартай албан бичгээр ирүүлсэн зааврын дагуу сумдын Сонгуулийн хороодод 24.2 сая төгрөгийг хуваарилсан байна.

Хүснэгт № 2

№	Сумын нэр	Бичиг хэргийн зардал /мян.төг/	Шуудан холбооны зардал /мян.төг/	Унааны зардал /мян.төг/	Санал авах байрны тохижуулах зардал /мян.төг/	Урамшуулал, хоолны зардал /мян.төг/	Болзошгүй зардал /мян.төг/	Нийт дүн /мян.төг/
1	Баруунтуруун	250.0	300.0	910.0	300.0	5640.0	50.0	7450.0
2	Давст	250.0	300.0	910.0	300.0	0.0	50.0	1810.0
3	Өндөрхангай	300.0	300.0	910.0	300.0	5640.0	0.0	7450.0
4	Түргэн	250.0	300.0	910.0	300.0	5640.0	0.0	7450.0
	ДҮН	1050.0	1200.0	3640.0	1200.0	16920.0	100.0	24160.0

/Эх сурвалж: /Сумдын сонгуулийн хорооны зардлын тайлан/

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт "Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тухайн жилийн төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ" гэж заасны дагуу Улсын бүртгэлийн Ерөнхий газраас Орон нутгийн нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд зориулан Увс аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст 6.7 сая төгрөгийг хуваарилсан байна.

Түүнчлэн дээрх хуулийн 10.3 дахь хэсэгт "Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг Цагдаагийн байгууллагын тухайн жилийн төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ" гэж заасны дагуу Цагдаагийн ерөнхий газраас Орон нутгийн нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд зориулан Увс аймаг дахь Цагдаагийн газарт 0.8 сая төгрөгийг хуваарилсан байна.

² Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах журмын 2.3 дахь хэсэгт "аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, төв комисс Сонгуулийн Ерөнхий Хорооноос өгсөн зөвлөмж, аргачлалын дагуу сум, дүүргийн сонгуулийн хороо, салбар комисст дараах зардлыг хуваарилна", 2.3.1 дэх заалтад "санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал", 2.3.2 дахь заалтад "бичиг хэргийн зардал", 2.3.3 дахь заалтад "шуудан холбооны зардал", 2.3.4 дахь заалтад "унааны зардал", 2.3.5 дахь заалтад "албан томилолтын зардал", 2.3.6 дахь заалтад "Сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал", 2.3.7 дахь заалтад "сургалтын зардал", 2.3.8 дахь заалтад "Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал", 2.3.9 дэх заалтад "Сонгуулийн бичиг баримт болон техник хэрэгслийг аймаг, нийслэлийн сонгуулийн хорооноос хүлээн авах, хүлээлгэн өгөх зардал", 2.3.10 дахь заалтад "болзошгүй зардал"

БҮЛЭГ 2. Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулахад улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалтын талаар Сонгуулийн ерөнхий хорооноос зөвлөмж чиглэл өгч ажилласан байна.

2.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Сонгуулийн Ерөнхий хорооны 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 2.2³, 2.3⁴ дахь заалтын дагуу аймаг, сумдын сонгуулийн хороодод хуваарилан зарцуулжээ. Батлагдсан төсвийн зарцуулалт дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт № 3

Д/д	Зардлын нэр	Төсөв /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/		Үлдэгдэл /мян.төг/
			Сумд	Аймгийн сонгуулийн хороо	
1	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	150.0		150.0	-
2	Үнэмлэх хэвлэх зардал	200.0	150.0	0.0	50.0
3	Сургалтын зардал	660.0	0.0	0.0	660.0
4	МТБ, даамлын сургалтын зардал	80.0	0.0	0.0	80.0
5	Бичиг хэргийн зардал	1300.0	815.0	300.0	185.0
6	Шуудан холбооны зардал	1600.0	1050.0	400.0	150.0
7	Унааны зардал	5040.0	3080.0	1400.0	560.0
8	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	1200.0	900.0	0.0	300.0

³ Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах журмын 2.2 дахь хэсэгт “Сонгуулийн Ерөнхий Хороо нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комисст дараах зардлыг хуваарилна”, 2.2.1 дэх хэсэгт “Сонгуулийн бичиг баримт болон техник хэрэгслийг сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах, тээвэрлэх зардал”, 2.2.2 дахь хэсэгт “Тогтоол, протокол, албан бичгийн хэвлэмэл хуудас, маягт хэвлүүлэх зардал”, 2.2.3 дахь хэсэгт “Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал”, 2.2.4 дахь хэсэгт “Дүн мэдээ дамжуулах зардал”, 2.2.5 дахь хэсэгт “Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал”, 2.2.6 дахь хэсэгт “Сонгуулийн байгууллагын ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон сургалтын зардал”, 2.2.7 дахь хэсэгт “Сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал”, 2.2.8 дахь хэсэгт “Бичиг хэргийн зардал” 2.2.9 дахь хэсэгт “Шуудан холбооны зардал”, 2.2.10 дахь хэсэгт “Унааны зардал”, 2.2.11 дэх заалтад “Албан томилолтын зардал”, 2.2.12 дахь заалтад “Үнэмлэх хэвлэх зардал”, 2.2.13 дахь заалтад “Сурталчилгааны зардал”, 2.2.14 дахь заалтад “Болзошгүй зардал”, 2.2.15 дахь заалтад “Бусад зардал”

⁴ Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах журмын 2.3 дахь хэсэгт “аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, төв комисс Сонгуулийн Ерөнхий Хорооноос өгсөн зөвлөмж, аргачлалын дагуу сум, дүүргийн сонгуулийн хороо, салбар комисст дараах зардлыг хуваарилна”, 2.3.1 дэх заалтад “санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал”, 2.3.2 дахь заалтад “бичиг хэргийн зардал”, 2.3.3 дахь заалтад “шуудан холбооны зардал”, 2.3.4 дахь заалтад “унааны зардал”, 2.3.5 дахь заалтад “албан томилолтын зардал”, 2.3.6 дахь заалтад “Сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал”, 2.3.7 дахь заалтад “сургалтын зардал”, 2.3.8 дахь заалтад “Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал”, 2.3.9 дэх заалтад “Сонгуулийн бичиг баримт болон техник хэрэгслийг аймаг, нийслэлийн сонгуулийн хорооноос хүлээн авах, хүлээлгэн өгөх зардал”, 2.3.10 дахь заалтад “болзошгүй зардал”

9	Саналын хуудас, ICP төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх унаа, томилолтын зардал	6890.0	0.0	4620.0	2270.0
10	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо унааны зардал	260.0	0.0	0.0	260.0
11	Сонгуулийн автоматжуулсан системийн зардал /Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх/	240.0	0.0	0.0	240.0
12	Мэдээ дамжуулах унааны зардал	210.0	0.0	0.0	210.0
13	Сурталчилгааны зардал	2000.0	0.0	0.0	2000.0
14	Томилолтын зардал	4178.0	0.0	3472.0	706.0
15	Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	20210.0	16920.0	3290.0	0.0
16	Мэдээлэл технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	2350.0	0.0	2350.0	0.0
17	Болзошгүй зардал	1500.0	0.0	0.0	1500.0
Дүн		48068.0	22915.0	15982.0	9171.0

/Эх сурвалж: /аймгийн сонгуулийн хорооны зардлын тайлан/

Аймгийн сонгуулийн хороонд 48.1 сая төгрөг хуваарилагдсанаас сумдын сонгуулийн хороо 22.9 сая, аймгийн сонгуулийн хороо 16.0 сая төгрөгийг тус тус зарцуулж, 9.2 сая төгрөгийг хэмнэж ажилласан байна.

Орон нутгийн нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах ажлын хүрээнд Улсын бүртгэлийн Ерөнхий газраас 6.7 сая төгрөгийн санхүүжилт олгосноос сонгуульд ажилласан ажилтны мөнгөн урамшуулал, хоолны мөнгө, сонгогчдын нэрсийн жагсаалт хэвлэх, тоног төхөөрөмж тээвэрлэхэд нийт 6.2 сая төгрөгийг зарцуулж, 529.7 мянган төгрөгийг хэмнэж, үлдэгдлийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах ажлын хүрээнд Цагдаагийн Ерөнхий газраас олгосон 800.0 мянган төгрөгийн санхүүжилтийг санал авах байрны хамгаалалтад ажилласан Увс аймаг дахь Цагдаагийн газрын албан хаагчдын хоолны зардалд зарцуулсан байна.

2.2. Зардлын гүйцэтгэлийг журамд заасны дагуу тайлагнасан байна.

Орон нутгийн нөхөн болон дахин сонгууль зохион байгуулахтай холбогдон Улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлийг Сонгуулийн Ерөнхий хорооны 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах журам"-ын 4.1 дэх хэсэгт "Сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн хадгалж, бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хөтөлнө" гэж заасны дагуу тайлагнасан байна. Үүнд:

		Хүснэгт № 4		
№	Зардлын нэр	Төсөв /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Үлдэгдэл /мян.төг/
1	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	150.0	150.0	
2	Үнэмлэх хэвлэх зардал	200.0	150.0	50.0
3	Сургалтын зардал	660.0	0.0	660.0
4	МТБ, даамлын сургалтын зардал	80.0	0.0	80.0

5	Бичиг хэргийн зардал	1300.0	1115.0	185.0
6	Шуудан холбооны зардал	1600.0	1450.0	150.0
7	Унааны зардал	5040.0	4480.0	560.0
8	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	1200.0	900.0	300.0
9	Саналын хуудас, ИСР төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх унаа, томилолтын зардал	6890.0	4620.0	2270.0
10	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо унааны зардал	260.0	0.0	260.0
11	Сонгуулийн автоматжуулсан системийн зардал /Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх/	240.0	0.0	240.0
12	Мэдээ дамжуулах унааны зардал	210.0	0.0	210.0
13	Сурталчилгааны зардал	2000.0	0.0	2000.0
14	Томилолтын зардал	4178.0	3472.0	706.0
15	Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	20210.0	20210.0	0.0
16	Мэдээлэл технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	2350.0	2350.0	0.0
	Болзошгүй зардал	1500.0	0.0	1500.0
17	Төвлөрүүлэх /сум/		1245.0	-1245.0
18	Төвлөрүүлэх /аймаг/		7926.0	-7926.0
	НИЙТ ДҮН	48068.0	48068.0	0.00

Эх сурвалж: /аймгийн сонгуулийн хорооны зардлын тайлан/

2.3. Хөрөнгийн зарцуулалтын талаар Сонгуулийн Ерөнхий хорооноос зөвлөмж чиглэл өгч ажилласан байна.

Сонгуулийн Ерөнхий хорооны 2016 он 04 дүгээр тогтоолын 1-р хавсралтаар “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3.5 дахь хэсэгт “Сонгуулийн Ерөнхий Хороо нь сонгуулийн хороодын зардлын дансыг Сангийн яамны Төрийн сангийн газарт нээлгэн, сонгууль дууссаны дараа зохих журмын дагуу хаалгана” гэж заасны дагуу аймгийн сонгуулийн хороо нэг, 4 сумдын сонгуулийн хороо тус бүр нэг данс нээлгэсэн байна. Тухайн дансаар сонгуулийн зардлын зарцуулалтыг хийжээ.

Журмын 3.1 дэх хэсэгт “Сонгуулийн Ерөнхий хороо нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина” гэж заасны дагуу сонгуулийн Ерөнхий хорооноос аймгийн сонгуулийн хороонд, сумдын сонгуулийн хороонд, аймгийн Сонгуулийн хороо нь сонгуулийн зардлын зарцуулалтын талаар цахимаар чиглэл өгч ажилласан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аймгийн Сонгуулийн хороо нь Сонгуулийн Ерөнхий хорооноос ирүүлсэн зааврын дагуу төсвийг хуваарилсан байна.
2. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.
3. Зардлын гүйцэтгэлийг журамд заасны дагуу тайлагнасан байна.
4. Хөрөнгийн зарцуулалтын талаар Сонгуулийн Ерөнхий хорооноос зөвлөмж чиглэл өгч ажилласан байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



УВС АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165
Утас: 7045-4708, Факс: 7045-4095

2022. 07. 07 № 7
танай _____-ны № _____-т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Нийцлийн аудитын дүгнэлттэй танилцлаа.
Танай аудитын дүгнэлттэй санал нэг байна.

СОНГУУЛИЙН ХОРООНЫ
ДАРГА

Г.БОЛОР-ЭРДЭНЭ

D:\d\Албан бичиг\tamga A5.docx

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

Аймгийн Сонгуулийн хорооноос ирүүлсэн 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 7 дугаартай албан бичигт “Нийцлийн аудитын дүгнэлттэй танилцлаа. Танай аудитын дүгнэлттэй санал нэг байна” гэсэн тул тайлбар өгөх шаардлагагүй гэж үзлээ.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

С.БАТСАЙХАН
Ч.МӨНХТОГТОХ
Б.ЭНХМАНДАЛ